



ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Статистикийн үндэсний хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
2.2 ТЭРБУМ ДОЛЛАР



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
8.4%



НИЙТ ХАДГАЛАМЖ
11 ИХ НАЯД ТӨГ



ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС
1.013 НЭГЖ



ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
926 ТЭРБУМ ТӨГ



ИПОТЕКИЙН ЗЭЭЛДЭГЧДИЙН ТОО
183 ӨРХ

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2017 онд: +4.0%, 2018 онд: +3.0%

Инфляци: 2017 онд: +3.0%, 2018 онд: +3.4%

Урсгал тэнцэл: 2017 онд ДНБ-ий -6.4%, 2018 онд: -8.5%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) тайландаа тоймлосон байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zwQ36D>

ДНБ-ий өсөлт: 2017 онд: +2%, 2018 онд: +2.5%

Инфляци: 2017 онд: +4.4%, 2018 онд: +6%


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2017 онд: -4.9%, 2018 онд: -8.7%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 12-р сарын байдлаар (1741) тэрбумын алдагдалтай гарав.

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 23.7 хувиар өсч, зарлага 5.7 хувиар буурсан бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1741 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Энэ нь өнгөрсөн сараас 761 тэрбумаар нэмэгдсэн үзүүлэлт юм. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 52.5 хувь буурсан үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 15 төгрөгөөр буурав.

Арванхоёрдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 49 төгрөг буюу 2 хувиар буурч, өмнөх сартай харьцуулахад 15.3 төгрөг буюу 0.6 хувиар буурч 2433.49 төгрөг болов. 11-р сард гадаад валютын нөөц 2.2 тэрбум ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 75.7% нэмэгдсэн байна.



Инфляцийн түвшин өмнөх сараас өөрчлөлтгүй.

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2017 оны 12-р сард өмнөх сараас 0.5 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар өсөв. Ингэж өсөхөд хүнсний бараа, тээврийн хэрэгсэл, орон сууц, ус, цахилгаан үнэ хамгийн их өссөн байна.



Гадаад худалдааны тэнцэл 1865 сая.ам доллар болов.

2017 оны эхний арван хоёр сарын байдлаар нийт барааны эргэлт 10.5 тэрбум төгрөг буюу 27 хувиар өсөв. Экспорт өмнөх сараас 6.2 хувиар буурч, импорт өмнөх сараас 0.7 хувиар буурч худалдааны тэнцэл 1865 сая ам.долларын ашигтай гарлаа.



12-Р САРЫН ОНЦЛОХ: МУ-ЫН ГАДААД ӨР



Эх сурвалж: Монголбанк

2017 оны гуравдугаар улиралд Засгийн газрын нийт гадаад өр 6.2 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 26 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас 3Г-ын өр 4 хувь (224 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 3% (808 сая ам.доллар)-иар тус тус өссөн байна.

Харин төв банкны өр өмнөх улирлаас 2% (33 сая ам.доллар), хадгаламжийн байгууллагуудын өр 3% (72 сая ам.доллар), бусад салбарын өр 6% (207 сая ам.доллар), Шууд хөрөнгө оруулалт: компани хоорондын зээллэг 4% (271 сая ам.доллар)-аар тус тус өссөн байна. Нийт гадаад өрийн 24%-ийг засгийн газрын өр, 7%-ийг Төв банкны өр, 9%-ийг хадгаламжийн байгууллагуудын өр, 31%-ийг бусад салбаруудын өр, 29%-ийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.

2017 оны эцэст улсын төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 6.6 их наяд төгрөг болж нийт өр төлбөрт 5.3 их наяд төгрөг (төсвийн орлогын 88%-тай тэнцэх хөрөнгийг өр төлөхөд зарцуулсан байна. Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 26 тэрбум ам.доллар болсноор дотоодын нийт бүтээгдэхүүний 85 хувьд хүрээ.

САРЫН ОНЦЛОХ: ОУВС-ИЙН САНХҮҮЖИЛТ, МОНГОЛ БАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГО

- Монгол Улс ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд 79.1 сая ам.долларын санхүүжилт авах болж ОУВС-ийн захирлуудын зөвлөл гурван жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн нэг болон хоёрдугаар шатны үнэлгээг энэ сарын 15-ны өдөр хэлэлцэж нийт 83.9ы сая зээлжих тусгай эрх буюу 118.6 сая ам.долларын санхүүжилт олгохоор болсон.
- 12-р сарын 22-ны өдөр Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлийн хуралдаанаар бодлогын хүүг 1 нэгж хувиар буулгаж 11 хувь болгов. Тус өөрчлөлт нь банкнаас баримталж буй мөнгөний бодлого аль чиглэлд өөрчлөгдөж буйг илтгэхийн сацуу банк хоорондын захын хөтөч хүүний үүргийг гүйцэтгэнэ. Банк хоорондын захын арилжааны жигнэсэн дундаж хүү нь Монголбанкны бодлогын хүүтэй ойролцоо түвшинд тогтохоор хүлээгддэг. Монголбанк Төв банкны долоо хоногийн хугацаатай үнэт цаасны хүүг 2007 оны 7 дугаар сараас бодлогын хүү болгон зарласан. Монголбанкны бодлогын хүү хөдлөхөд дагаад арилжааны банкуудын хадгаламжийн хүү, улмаар зээлийн хүүнд өөрчлөлт ордог.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 12-р сар 2017 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 12-р сар 2017 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn